



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 07 өдөр Дугаар 33

Хэрлэн сум

XXXIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 10:30 цагт аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн хурлын танхимд 83,2 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэлт гүйцэтгэгч аж, ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг эхлүүлэх эсэх, ХХI талбайн ажилчдын ээлж солих талаар танилцууллаа.

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа,

2. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч компаний жолооч иргэн Б-г коронавируст халдварын сэжигтэй тохиолдлоор бүртгэн ХӨСҮТ-ийн лавлагаа лабораторт илгээсэн PCR шинжилгээний хариуг танилцууллаа.

Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч "Монст-Ази", "Дорнын хөгжил транспорт" ХХК-уудын халдвар хамгааллын дэглэмийг баримтлан тээвэрлэлтийн үйл ажиллагааг эхлүүлэх,

2. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч "Жилин хуа ян" ХХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийг бүрэн хангатаг түр зогсоохоор шийдвэрлэв.

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.1. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн туслан гүйцэтгэгч "Монст-Ази", "Дорнын хөгжил транспорт" ХХК-ууд өвчнөөс урьдчилан сэргийлэх халдвар

хамгааллыг сахиулах талаар Мэргэжлийн хяналтын газраас хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгч биелэлтийг хангуулан хяналт тавьж ажиллахыг,

1.2."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний газрын тос тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч "Жилин хуа ян" ХХК-нд хугацаатай үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг бүрэн хангатаг тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоохыг,

Хоёр.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа:

2.1."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний ажилчдын ээлж солих үед халдвар хамгааллын дэглэмийг сахиулж тээврийн хэрэгсэлд 8-аас ихгүй зорчигчтой байхаар чиглэл өгч, Хэрлэн сум руу ороход асуумж авах, ариутгал халдваргүйтгэл хийж оруулах, хяналт тавьж ажиллахыг,

2.2.Вируслогийн шинжилгээний хариуг үндэслэн ойрын хавьтлын Халдвартын тасгийн тусгаарлалтад байгаа иргэн Л.Гантөгс, А.Баярзоригт, Л.Владимир нарыг газрын тосны тээвэрлэлтийн туслан гүйцэтгэгч компаний кемп рүү буцаахыг,


2.3.Вируслогийн шинжилгээний хариуг үндэслэн ойрын хавьтал иргэн Л.Владимирийн гэр бүлийн гишүүн В.Путин, В.Ариунсанаа, М.Төгөлдөр, Т.Энхсайхан нарыг Халдвартын тасгийн тусгаарлалтаас гаргаж Эрдэнэцагаан сум руу буцаахыг,


2.4.Вируслогийн шинжилгээний хариуг үндэслэн ойрын хавьтлын Газрын тос ХХI талбайд тусгаарлагдаж буй 5 иргэдийн хөл хориог чөлөөлөхийг,

2.5.Вируслогийн шинжилгээний хариуг үндэслэн газрын тосны ХХI талбайн хөл хориог чөлөөлөхийг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.6.Иргэн А.Баярзоригтыг БОЭТ-ийн Халдвартын тасагт эмчилгээний хугацааг дуустал үргэлжлүүлэн тусгаарлахыг тус тус үүрэг болгов.

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА